



© Хүүхдийг Илгээх Сэн

Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицохуй

ЕБС-ИЙН СУРАГЧДАД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



“Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төсөл

Уур амьсгалын өөрчлөлт, түүнд дасан зохицохуй

ЕБС-ийн сурагчдад зориулсан гарын авлага

Улаанбаатар хот
2026

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ, ТҮҮНД ДАСАН ЗОХИЦОХУЙ

Бэлтгэсэн: З. Баасансүрэн
Д. Доржханд
Хянан тохиолдуулсан: Э. Лхагважаргал
Зөвлөх: Л. Баян-Алтай
Дизайнер: Л.Лхагвачимэг

АГУУЛГА

Өмнөх үг	4
Сэдэв 1. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ	5
1.1 Уур амьсгал ба цаг агаар	6
1.2 Уур амьсгалын өөрчлөлт ба Дэлхийн дулаарал	7
1.3 Хүний буруутай үйлдлүүд ба Хүлэмжийн хий	9
1.4 Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө	10
Сэдэв 2. БИДНИЙ ЭКОЛОГИЙН УЛ МӨР	12
2.1 Дэлхийн даац ба Бидний ул мөр	13
2.2 Монгол хүний экологийн ул мөр	14
Сэдэв 3. БИД УЛ МӨРӨӨ ХЭРХЭН БАГАСГАХ ВЭ?	15
3.1 Байгальд ээлтэй амьдрах 5 алхам	17
Хог хаягдлын “менежер” болцгооё!	17
Эрчим хүчний “манаанд” гарцгаая!	19
Усыг зөв, зохистой хэрэглэж хэвшье!	20
Агаарын бохирдлыг бууруулахад хувь нэмрээ оруулъя!	21
Хоолондоо анхааръя!	22
Сэдэв 4. БИД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?	23
4.1 Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хийсэн бодит алхмууд	24
Сэдэв 5. МОД ЯАГААД ЧУХАЛ ВЭ?	26
5.1 Мод ба ойн ач холбогдол	27
5.2 Хамтдаа мод тарьцгаая	28
5.3 Ногоон сайн дурын ажил	30
5.4 Налайх дүүргийн ой болон газар зүйн бүтэц	31
Ашигласан ном зүй	33

ӨМНӨХ ҮГ



Та бидний амьдарч буй энэ цаг үе бол хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн онцгой, хариуцлагатай мөч юм. Дэлхий ертөнц өдөр бүр хувьсан өөрчлөгдөж, цаг агаар тогтворгүй болж байна. Зарим газарт хэт халж, заримд нь ган, зуд, хүчтэй салхи, үерийн давтамж ихсэж байгааг та бүхэн анзаарч байгаа байх. Эдгээр үзэгдэл нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой бөгөөд өнөө үеийн хүүхдүүдийг “Уур амьсгалын хямралын үед төрсөн” гэж хэлж болно.

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн үер, ган гачиг, ой хээрийн түймэр зэрэг үзэгдэл та бүхний амьдралд илүү давтамжтай тохиолдох магадлалтай. Түүнчлэн манай улсад, тэр дундаа Налайх дүүрэгт агаарын бохирдол, хөрсний элэгдэл, цөлжилт зэрэг байгаль орчны асуудал тулгамдсан хэвээр байна. Иймд Хүүхдийг Ивээх Сан нийслэлийн Налайх дүүрэгт ойн төгөл байгуулах, хүүхэд, залуусын экологийн боловсролыг нэмэгдүүлэх зорилготой “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийг 2024 оноос хэрэгжүүлж эхэлсэн юм.

Энэхүү гарын авлагыг БНСУ-ын Хүүхдийг Ивээх Сангийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн хүрээнд боловсруулсан бөгөөд та бүхэнд уур амьсгалын өөрчлөлт гэж юу болох, яагаад уур амьсгалын өөрчлөлт болж байгаа болон бид энэхүү нөхцөл байдлыг хэрхэн даван туулж, дасан зохицож амьдрах талаар мэдлэг олгох зорилготой. Түүнчлэн мод тарих, байгаль орчноо хайрлах арга дадлыг энгийн ойлгомжтойгоор танилцуулах зорилготой.

Та бүхэн энэхүү гарын авлагаас зөвхөн мэдлэг аваад зогсохгүй, байгальд ээлтэй, зөв дадлыг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлж, мод тарих, хүрээлэн буй орчноо хамгаалах сэдэл авч, ирээдүйд байгальдаа ээлтэй, хариуцлагатай иргэн болох болно гэдэгт итгэж байна.

Та бүхэнд амжилт хүсье!

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Л. Баян-Алтай

Уур амьсгалын өөрчлөлт



1.1 УУР АМЬСГАЛ БА ЦАГ АГААР

Уур амьсгал (Climate) гэдэг нь тухайн газар нутгийн олон жилийн турш ажиглагдсан цаг агаарын дундаж төлөв байдал юм. Өөрөөр хэлбэл, тухайн бүс нутаг ерөнхийдөө дулаан уу, хүйтэн үү, хэдэн хэм хүрч халдаг, өвөлдөө хэр хүйтэрдэг, хуурай эсвэл бороо, цас хэр давтамжтай ордог болохыг тодорхойлдог. Уур амьсгалыг ихэвчлэн 30 ба түүнээс дээш жилийн мэдээлэлд үндэслэн тодорхойлдог.

Цаг агаар (Weather) гэдэг нь тухайн агшин болон ойрын хугацаанд тухайн газар нутагт ажиглагдаж буй байгалийн нөхцөл байдал юм. Цаг агаар нь өнөөдөр, маргааш, ойрын хэдэн хоногт ямар байхыг илэрхийлдэг бөгөөд байнга, хурдан өөрчлөгдөж байдаг онцлогтой.

Агаарын температур дулаарах, хүйтрэх, бороо орох, салхи шуурга болох, нартай эсвэл бүрхэг байх зэрэг нь бүгд цаг агаарын төлөв байдал юм. Иймээс цаг агаарын мэдээг бид өдөр бүр сонсож, ажлаа төлөвлөдөг. Жишээлбэл, Өчигдөр нартай дулаахан байсан бол өнөөдөр салхитай, цас орж байна.

Уур амьсгал ба цаг агаарын ялгаа

Шинж чанар	Цаг агаар (Weather)	Уур амьсгал (Climate)
Хугацаа	Богино (өнөөдөр, маргааш, ойрын хэд хоног)	Урт (30 ба түүнээс дээш жил)
Хэмжигдэхүүн	Өнөөдрийн температур, хур тунадас	Олон жилийн дундаж үзүүлэлт
Өөрчлөлт	Маш хурдан, ойр ойрхон өөрчлөгдөнө.	Маш удаан, аажмаар өөрчлөгддөг.
Урьдчилсан мэдээ	Ойрын өдрүүдийн байдлыг урьдчилан мэдэх боломжтой.	Ирээдүйн ерөнхий хандлагыг тооцоолно.

“Уур амьсгал бол бидний хүлээлт (шүүгээнд бэлдсэн хувцас), харин цаг агаар бол бидэнд тохиолдсон бодит байдал (өнөөдөр өмссөн хувцас) юм.”

Роберт А. Хайнлайн (Шинжлэх ухааны зөгнөлт зохиолч)

Орчин үеийн хүүхдүүдийг уур амьсгалын хямралын үед төрсөн хүүхдүүд гэдэг. Тэгвэл та бүхний амьдарч буй дэлхий, байгаль орчин хэрхэн өөрчлөгдөж байна вэ?

Та бүхэн интернэт болон бусад эх сурвалжаас уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны ямар асуудал илэрч байгааг судлаарай. Мөн уур амьсгалын хямрал, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөг багасгахын тулд бид юу хийж чадах талаар бодож үзээрэй.

1.2 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТ БА ДЭЛХИЙН ДУЛААРАЛ

Уур амьсгалын өөрчлөлт (Climate Change) гэдэг нь хүний үйл ажиллагаанаас үүдэн дэлхийн дулаарал болж, дэлхийн уур амьсгалын тогтолцоонд гарч буй өөрчлөлт юм. Дэлхий улам дулаарч байгаагийн шалтгаан юу вэ ?



Үүнийг ойлгохын тулд эхлээд “Хүлэмжийн хий” гэж юу болохыг мэдэх хэрэгтэй.


Дэлхийг тойроод агаар мандал буюу “хөнжил” хучиж байдаг. Энэ хөнжил нь нарны илчийг өөртөө шингээж, дэлхийг дулаан байлгадаг. Хэрэв хүлэмжийн хийн давхарга ихэсвэл дэлхийн дундаж температур нэмэгдэж, улам халуун болно.

Гэтэл хүн төрөлхтөн үйлдвэр, машин, цахилгаан станцаас асар их утаа гаргаж, тэрхүү байгалийн “хөнжил”-ийг улам зузаан, улам хүнд болгочихсон. Энгийнээр тайлбарлавал, Бид зуны халуунд өвлийн зузаан хөнжил нөмөрч байна гэсэн үг. Энэ нь дэлхийн дулаарал юм.

<p>GREENHOUSE EFFECT</p> <p>Solar Radiation</p> <p>Radiated Dispersed in space</p> <p>Radiated Back to the earth</p> <p>Greenhouse Gases</p>	<p>Хүн төрөлхтөн сүүлийн 150 жилд дэлхийн дундаж температурыг 1,1 градусаар нэмэгдүүлсэн.</p> <p>Үүний тал хувь нь сүүлийн 30 жилд нэмэгдсэн бөгөөд сүүлийн 10 жилийн дундаж температур нь сүүлийн 150 жилийн рекордыг эвдсэн.</p> <p>Судлаачид агаарын дундаж температур цаашид ч нэмэгдэх төлөвтэй гэж үзэж байна. Дэлхийн 4,5 тэрбум жилийн түүхэнд дундаж температур +10°C нэмэгдэх нь асар их өөрчлөлт юм.</p>
---	---

Бидний ялгаруулж буй хүлэмжийн хийг багасгаж, аль хэдийнэ ялгарсан хүлэмжийн хийг бууруулах замаар нийт нүүрстөрөгчийн ялгаруулалтыг тэнцвэржүүлж, 0 болгохыг “нүүрстөрөгчийн саармагжилт” гэж нэрлэдэг.

1. Дэлхийн температурын өөрчлөлтийн графикаас 1880 оноос 2020 он хүртлэх өөрчлөлтийг харж харьцуулаарай.



2. Дэлхийн дундаж температур нэмэгдэж байгаа шалтгаан юу вэ? Өөрийн бодлоо хуваалцана уу.

.....

.....

.....

.....

3. Дараах түлхүүр үгсийг ашиглан уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмрээ оруулах агуулгатай уриа бичээрэй.

- Мэдэж авах
- Хуваалцах
- Анхаарал хандуулах
- Илэрхийлэх
- Үйлдэл хийх
- Хамтдаа хийх

1.3 ХҮНИЙ БУРУУТАЙ ҮЙЛДЛҮҮД БА ХҮЛЭМЖИЙН ХИЙ

Хүлэмжийн хий (Greenhouse gases) нь нүүрстөрөгчийн давхар исэл (CO₂), метан (CH₄) хийг ялгаруулдаг.

Эдгээр нь дараах 4 замаар голчлон үүсдэг:

Чулуужсан түлш шатаах	Бид гэрээ халаах, гэрэл асаах, тээврийн хэрэгсэл ашиглахад нүүрстөрөгч агаар мандалд дэгддэг.
Ой модыг устгах	Мод агаар дахь нүүрстөрөгчийн давхар ислийг сорж аваад, бидэнд хүчилтөрөгч бэлэглэдэг. Гэтэл хүмүүс байшин барих, тариалангийн талбай бий болгохын тулд олон сая модыг огтолж, агаар цэвэрлэх “шүүлтүүр”-ийг устгаж байна.
Хөдөө аж ахуй, Мал аж ахуй	Үхэр, хонь зэрэг хивэгч амьтад хоол боловсруулах явцдаа метан (CH ₄) хийг ялгаруулдаг. Метан нь CO ₂ -оос ч илүү дулааныг хадгалах чадвартай, хүчтэй хүлэмжийн хий юм.
Хог хаягдал	Хуванцар, органик хог байгальд задарч муудахдаа агаар мандалд хорт хийнүүд ялгаруулдаг.

Уур амьсгалын хямралаас үүдэлтэй байгаль орчны асуудалд голдуу эмзэг бүлгийн иргэд өртсөн байдаг. Газарзүйн байршил, нас зэргээс шалтгаалан уур амьсгалын хямралд өртөх нөлөөлөл нь харилцан адилгүй байна.

ДЭЛХИЙН ДУЛААРАЛ: ХӨГЖИЖ БУЙ ОРНУУДЫН ИРГЭД ХАМГИЙН ИХ ХОХИРЧ БАЙНА

2022.09.01/The Hankyoreh

Олон улсын хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхи сул улс орнуудын тоонд Баруун Африк, Төв Африк, Зүүн Африк, Өмнөд Ази, Латин Америк-Карибын бүс нутаг, жижиг арлын хөгжиж буй улс орнууд болон Арктикийн бүс нутаг багтдаг.

2010-2020 онд эдгээр бүс нутгуудад үер, ган гачиг, шуурганы улмаас нас баралтын түвшин нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадвар өндөртэй бүс нутгуудтай харьцуулахад 15 дахин өндөр байжээ. Мөн нэг улсын хүрээнд авч үзвэл, уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хохирол нь ихэвчлэн эмзэг бүлэгт илүү нөлөөлдөг болохыг НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн шинжээчдийн 2022 оны тайланд онцолжээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас хэт давтамжтай цаг уурын үзэгдэл нэмэгдэхийн хэрээр олон сая хүн хүнсний аюулгүй байдлын эрсдэлд орж, усны хомсдол, хүнс тэжээлийн дутагдалтай тулгарч байна. Ялангуяа бага орлоготой өрхүүд, хүүхдүүд, өндөр настнууд, жирэмсэн эмэгтэйчүүд хамгийн их нөлөөлдө өртөж байгааг тус тайланд дурджээ.

1.4 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ

Ган, үер, ой хээрийн түймэр болон халуун давалгаа зэрэг байгалийн гамшиг олширч байна. Ургац хомсдох, ундны ус багасах зэргээр хүнсний болон усны аюулгүй байдал алдагдаж байна.

Гэхдээ дээрх асуудал хүн бүрт адил нөлөөлөхгүй. Тодруулбал, Улс орнууд баян, ядуугийн түвшнээсээ шалтгаалан уур амьсгалын өөрчлөлтөд харилцан адилгүй өртдөг. Энэ ялгаа нь үе хооронд ч ажиглагдаж байна. Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө жил ирэх тусам нэмэгдэж байгаа тул өнөө үед төрсөн хүүхдүүд амьдралынхаа турш өмнөх үеийнхнээсээ илүү олон байгалийн гамшиг, хүнд нөхцөлийг даван туулах төлөвтэй байна.



Ой хээрийн түймэр:

2020 онд төрсөн хүүхдүүд
1960 онд төрсөн хүмүүстэй
харьцуулахад ой хээрийн түймэрт
өртөх эрсдэл дунджаар 2 дахин
өндөр байна.



Үр тарианы хомсдол:

2020 онд төрсөн хүүхдүүд эцэг
эхийнхээ үеийнхнээс дунджаар
2,8 дахин их үр тарианы хомсдол
туулж магадгүй байна.



Ган гачиг:

2020 онд төрсөн хүүхдүүд 1960
онд төрсөн хүмүүсээс дунджаар
2,6 дахин их ган гачгийг туулж
өнгөрүүлэх төлөвтэй байна.



Үер:


2020 онд төрсөн хүүхдүүд
1960 онд төрсөн хүмүүстэй
харьцуулахад дунджаар 2,8 дахин
олон үерийн гамшигийг туулж
өнгөрүүлэх магадлалтай байна.



Халуун давалгаа:

2020 онд төрсөн хүүхдүүд 1960 онд төрсөн хүмүүстэй
харьцуулахад амьдралынхаа туршид дунджаар 6,8 дахин олон
халуун давалгааг туулж өнгөрүүлэх магадлалтай байна.


УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН НӨЛӨӨ



Халуун температур




Хүчтэй салхи, хар шуурга



Ган гачиг



Далайн усны түвшин нэмэгдэх



Биологийн төрөл зүйлийн алдагдал



Эрүүл мэндийн эрсдэл нэмэгдэх



Хоол хүнсний хомсдол




Ядуурал, нүүлгэн шилжилт

Бидний экологийн ул мөр



Экологийн ул мөр (Ecological Footprint) бол маш сонирхолтой бөгөөд чухал ойлголт юм. Бид өмнөх сэдвээр “Дэлхийн дулаарал”-ын тухай мэдэж авсан бол энэ удаад “Дэлхий бидний хэрэглээг даах уу?” гэдэг асуултад хариулт олох болно.



Экологийн ул мөр нь хүн байгальд амьдрахдаа байгалийн нөөцийг хэр их ашиглаж, буцаагаад хэр их хог хаягдал гаргаж байгааг хэмждэг үзүүлэлт юм.

Таны хийж буй үйлдэл бүр (машинаар явах, шинэ хувцас авах, мах идэх) байгальд үл үзэгдэх мөр үлдээдэг. Мөр том байх тусам та дэлхийг дулаарахад илүү их нөлөөлж байна гэсэн үг. Харин мөр жижиг байх тусам та дэлхийдээ ээлтэй амьдарч байна гэсэн үг.

Жишээ нь: Цас, элсэн дээр алхахад мөр үлддэг. Үүн шиг таны хэрэглээ, амьдралын хэв маягаас байгальд үлдэх ул мөр тодорхойлогддог.

Таны амьдралын бүх хэрэглээ экологийн ул мөрт нөлөөлдөг. Үүнд:

- Идэж буй хоол: Тариалангийн талбай, малын бэлчээр ашиглах;
- Өмсөж буй хувцас: Хөвөн тариалах талбай, хувцас үйлдвэрлэхэд зарцуулагдах ус;
- Амьдарч буй байшин: Барилгын материал болон эзэлж буй газар;
- Агаараа бохирдуулах хэмжээ: Нүүрсхүчлийн хий болон бусад хорт хий ялгаруулалт.

2.1 ДЭЛХИЙН ДААЦ БА БИДНИЙ УЛ МӨР

Экологийн ул мөрийг талбайн хэмжээгээр тооцдог бөгөөд нэг хүнд ойролцоогоор 1,7 га ногддог гэж тооцоолсон. Гэтэл өнөөдөр хүн бүрийн экологийн ул мөрийг тооцвол нэг хүнд 2,6 га ногдож байна. Энэ нь бид нэг хүнд ногдох байгалийн нөөцийг 1,5 дахин их ашиглаж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, хэрэглээгээ танахгүй энэ хэвээр байвал бидэнд нэг дэлхий хангалтгүй, 1,5 дэлхий хэрэгтэй гэсэн үг юм.

Өнөөдөр дэлхийн хүн ам 8,2 тэрбумд хүрсэн байна. Хүн төрөлхтөн биеэрээ жижигхэн ч, байгальд үзүүлж буй нөлөөгөөрөө асар том буюу бид дэлхийн нөөцийн 70-80%-ийг хэрэглэж байна.

Хүн төрөлхтөн уулсыг нүүлгэж, голын урсгалыг өөрчилж, олон сая жилийн турш газар дор байсан нүүрсийг шатааж, агаар мандалд цацаж байна. Дэлхий биднийг асуудалгүй даана. Харин хэт их хэрэглээ, шунал, утаа, хог хаягдлыг даахгүй гэдгийг “Уур амьсгалын өөрчлөлт” харуулж байна.

2.2 МОНГОЛ ХҮНИЙ ЭКОЛОГИЙН УЛ МӨР

Монгол Улс нь нэг хүнд ногдох экологийн ул мөрийн хэмжээгээр дэлхийд хамгийн өндөрт тооцогдох 5 улсын нэг юм. Монгол хүний экологийн ул мөр 7,7-10 га хүртэлх хэмжээнд хүрсэн нь дэлхийн дунджаас 3-4 дахин их үзүүлэлт болж байна.



Монгол хүний экологийн ул мөр багадаа 7,7 дэлхийн га-д хүрнэ гэдэг бол маш өндөр тоо юм. (Дэлхийн дундаж нь 2,7 орчим). Хэрэв дэлхийн бүх хүн Монгол хүн шиг амьдарвал бидэнд таван дэлхий хэрэгтэй болно гэсэн үг.


Нэг хүнд ногдох экологийн ул мөрийн хэмжээ эрс өндөр байгаа нь дараах хоёр том хүчин зүйлтэй холбоотой. Үүнд:

1. **Хар мангас (Нүүрс):** Цахилгаан, дулаан, тээврийн хэрэглээ (60% орчим).
2. **Шар мангас (Мал аж ахуй):** Малын тоо хэтэрч, бэлчээрээ идэж дуусгаж байгаа явдал (30-40% орчим).

Малын тоо толгой, бэлчээрийн доройтол зэрэг нь экологийн ул мөрийг нэмэгдүүлсээр байна.

Бэлчээрийн даац ба нөхөн сэргээгдэх хурд

Монголд экологийн ул мөр өндөр байгааг “Биологийн багтаамж” гэдэг ойлголтоор тайлбарладаг. Байгаль тодорхой хугацаанд нөхөн сэргээгддэг ч (Жишээ нь, өвс ургахдаа тодорхой хугацаа (30 хоног) зарцуулдаг, 70 сая мал тэр өвсийг ургаж амжаагүй байхад нь (10 хоногт) идчихдэг.) үндэс нь бэхжиж амжаагүй ургамлыг идсэнээс үүдэж хөрс нь суларч, дараа жил нь тэнд өвс ургахгүй. Харин тухайн газарт элс нүүж эхэлдэг. Ингэснээр экологийн ул мөрийг улам нэмэгдүүлж байна.



© <https://weather.gov.mn/>


Экологийн ул мөрөө багасгах аялал



Байгальд үлдэх ул мөрөө багасгаж, уур амьсгалын хямралыг даван туулахын тулд бид юу хийж чадах вэ? Юуны өмнө, бид байгалийн нөөцийг зөв зохистой хэмжээнд хэрэглэхэд суралцах хэрэгтэй.

Тэгвэл байгалийн нөөц гэж юу вэ?

Байгалийн нөөц гэдэг нь амьдралд хэрэгтэй, хүний гараар бүтээгдээгүй, байгальд бэлэн байдаг зүйлс юм. Үүнд ус, хөрс, ургамал, амьтан, эрдэс, эрчим хүчний эх үүсвэр зэрэг багтана. Эдгээр нь хоол хүнс, хувцас, орон байр, түлш, эрчим хүч, аж үйлдвэрийн түүхий эдийн эх үүсвэр болдог.



© <https://flyingcolorsscience.com/ml/natural-resources/>

Бид өдөр тутмын амьдралдаа байгалийн нөөцийг ашигласаар байдаг. Тухайлбал, Бидний өмсөж буй хувцас, хэрэглэж буй эд зүйлс, амьдарч буй орчин бүгд мод, ус, хөрс, эрдэс зэрэг байгалийн нөөцөөс бүрддэг. Тиймээс бидний өдөр тутмын үйлдэл байгальд шууд нөлөөлдөг.

Байгальд үлдэх ул мөрөө багасгахын тулд ус, цахилгаанаа хэмнэх, дахин ашиглах, хогоо ангилан ялгах зэрэг энгийн үйлдлүүдийг өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэх хэрэгтэй.

3.1 БАЙГАЛЬДАА ЭЭЛТЭЙ АМЬДРАХ 5 АЛХАМ

Хог хаягдлаа багасгая!

Хог хаягдал гэдэг нь зөвхөн “хаях зүйл” биш, харин буруу газарт байгаа “баялаг” гэж орчин үед үзэх болсон. Хог хаягдлыг ерөнхийд нь дараах байдлаар ангилдаг:

Энгийн хог хаягдал: Ахуйн хэрэглээнээс гардаг цаас, хуванцар, хүнсний үлдэгдэл, шил, мод гэх мэт.

Аюултай хог хаягдал: Хүн болон байгаль орчинд шууд хор хөнөөл учруулах чадвартай зүйлс. Үүнд: Зай хураагуур, эмнэлгийн хог, химийн бодис, тос масло, будгийн сав зэрэг орно. Эдгээрийг хэзээ ч энгийн хогтой хольж хаяж болохгүй.

Барилгын хог хаягдал: Барилга нураах, засахад гардаг бетон, тоосго, арматур гэх мэт.

Тэгвэл бидний хаясан хог байгальд хэр удаан задардаг вэ?

- Гадилын хальс: 3-4 долоо хоног
- Сонин, цаас: 1-2 сар
- Тамхины иш: 10-12 жил
- Гялгар уут: 20-100 жил
- Хуванцар сав: 450 жил
- Шил: 4000-аас дээш жил



Тиймээс хог хаягдлаа багасгаж, дахин ашиглаж байгальдаа ээлтэй амьдрах нь чухал. Та бүхэн дараах гурван алхмыг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж хэвшээрэй.

БАЙГАЛЬД ЭЭЛТЭЙ АМЬДРАЛЫН ЗР ЗАРЧИМ



1. Reduce-багасгах

Байгальд ээлтэй амьдрах хамгийн үр дүнтэй арга бол хог хаягдлыг анхнаасаа үүсгэхгүй байх явдал юм. Үүний тулд та дараах алхмуудыг хэрэгжүүлээрэй. Үүнд:

- Гялгар уутны оронд даавуун тор хэрэглэх
- Нэг удаагийн аяга, соруулаас татгалзах
- Хэрэгцээгүй тоглоом, хувцас зэргийг худалдан авахаас татгалзах
- Өөрийн гэсэн усны савтай болох.



2. Reuse-Дахин ашиглах

Зарим зүйлийг шууд хаялгүй, өөр зориулалтаар дахин ашиглах боломжтой.

- Ундааны саваа ашиглан цэцгийн сав хийх
- Хуучин хувцсаа дүүдээ өгөх, эсвэл өөр зүйл оёх
- Хэрэглэсэн цаасаараа сонирхолтой бүтээл хийх
- Шинэ утас, шинэ хувцас үнэхээр хэрэгтэй эсэхийг өөрөөсөө байнга асууж, ухаалаг худалдан авалт хийж хэвших.



3. Recycle-Дахин боловсруулах

Хог хаягдлаа ангилан ялгаж, дахин боловсруулах цэгт тушааж хэвших нь чухал.

- Лааз, хуванцар сав, цаасаа ангилж дахивар бүтээгдэхүүн худалдан авах цэгүүдэд тушаах
- Хогоо ангилан ялгаж сурах, хог дахин боловсруулах үйлдвэр, төслийн талаар мэдээлэл олж, найзуудаараа нэгдэж, хамтран ажиллах
- Гэртээ болон сургууль дээрээ хогоо ангилж хаяж хэвших.



ЭРЧИМ ХҮЧНИЙ “МАНААНД” ГАРЦГААЯ!

Эрчим хүч гэж аливаа зүйлийг хөдөлгөх, халаах, гэрэлтүүлэх чадварыг хэлнэ. Энгийнээр хэлбэл, Эрчим хүч нь бидний амьдралыг хөдөлгөгч гол хүч юм. Эдгээр нь хэрэглэх тусам багасаж, хэзээ нэгэн цагт дуусдаг, мөн шатаах үед байгаль орчинд хортой хий ялгаруулдаг.


Монгол Улс нь эрс тэс уур амьсгалтай тул эрчим хүчний хэрэглээ, үйлдвэрлэл нь бусад улстай харилцан адилгүй байдаг. Монголын цахилгаан, дулааны 90 гаруй хувийг нүүрсээр ажилладаг дулааны цахилгаан станцууд (ДЦС-3, ДЦС-4 г.м) үйлдвэрлэдэг. Энэ нь өвлийн утааны гол шалтгаануудын нэг юм. Түүнчлэн бид оргил ачааллын үед (оройн цагаар) ОХУ-аас цахилгаан худалдаж авдаг.

Монгол орон нар, салхины асар их нөөцтэй (Говийн бүс). Сүүлийн жилүүдэд Салхитын салхин парк, Төв аймгийн нарны станцууд ашиглалтад орсон ч нийт үйлдвэрлэлд эзлэх хувь нь бага хэвээр байна.

Яагаад эрчим хүчээ хэмнэх хэрэгтэй вэ?

- Цахилгаанаа хэмнэх нь станцад түлэх нүүрсний хэмжээг багасгаж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулна.
- Өрхийн зардлаа хэмнэнэ.
- Бид хэдий чинээ хэмнэлттэй байна, төдий чинээ гаднаас цахилгаан авах хэрэгцээ багасна.

Тиймээс хүүхдүүд та бүхэн өөрийн хийж, хэвшүүлж чадах хамгийн энгийн алхмуудыг дадал болгож байгальдаа болон гэр бүлдээ үнэтэй хувь нэмэр оруулах боломжтой.



Өдөр тутмын амьдралдаа хэвшүүлэх гурван алхам

1. Ашиглаагүй бол унтраа!

- Өрөөнөөс гарахдаа гэрлээ унтрааж,
- Ус буцалгагч, угаалгын машин зэрэг цахилгаан барааг ашиглаагүй л бол залгуурыг нь салгаж,
- Унтахдаа интернет, зурагтыг бүрэн салгаж хэвшээрэй.



2. Цэнэглэгчээ салгахаа мартуузай!

Утсаа 100% болтол цэнэглэгдсэн хойно ашигладаг дадалтай болоорой. Ингэснээр утасны батерей цэнэгээ сайн барихаас гадна цахилгаанаа хэмнэх ач холбогдолтой.

3. Дулаанаа хадгалъя!

Хүйтний улирлаас урьтаж гэртээ дулаалга хийгээрэй. Учир нь дулаан алдалт бага байх тусмаа цахилгаан болон түлшний зарцуулалт бага байдаг.

УСЫГ ЗӨВ, ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЖ ХЭВШЬЕ!

Гэр хорооллын иргэд усаа зөөж хэрэглэхдээ хөдөлмөр, цаг хугацаа зарцуулдаг учраас усыг хэмнэж хэрэглэдэг. Харин орон сууцны иргэдийн хувьд усыг “хямд, хязгааргүй” мэтээр хэмнэлтгүй хэрэглэдэг.

Хүн эрүүл амьдрахад хоногт хамгийн багадаа 50-100 литр ус шаардлагатай гэж ДЭМБ үздэг. Монголын нөхцөлд, ялангуяа Улаанбаатар хотод орон сууц болон гэр хорооллын өрхүүдийн усны хэрэглээ эрс ялгаатай байдаг. Тодруулбал, орон сууцны иргэд гэр хорооллын иргэдээс дунджаар 15-20 дахин их ус хэрэглэдэг. Орон сууцны оршин суугч хоногт дунджаар 150-230 литр ус хэрэглэдэг. Харин гэр хорооллын оршин суугч хоногт дунджаар 7-15 литр ус хэрэглэдэг.

Усаа хэмнэж хэрэглэхийн тулд та дараах дадлыг өөртөө хэвшүүлээрэй.

- Гар, шүдээ угаахдаа усыг тасралтгүй урсгалгүй, крантаа хааж хэвшээрэй. Крантаа хаалгүй гоожуулахад минутанд 5-10 литр ус ашиггүй урсдаг.
- Шүршүүрт орох хугацаагаа 5 минутаас хэтрүүлэхгүй байхыг хичээгээрэй.



АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХАД ХУВЬ НЭМРЭЭ ОРУУЛЪЯ!

Автомашинаас ялгардаг утаа нь агаарыг бохирдуулдаг гол хүчин зүйлсийн нэг. Налайх дүүрэг нь замын хөдөлгөөнд оролцож буй машины урсгалаар төвийн дүүргүүдтэй дүйцэхүйц ачаалалтай байдаг.

Автомашинны хөдөлгүүр дотор бензин эсвэл дизель түлш шатах үед химийн урвал явагдаж, энерги үүсэхийн зэрэгцээ олон төрлийн хорт хий, хатуу биетүүд ялгардаг. Үүнийг бид “утаа” гэж хардаг боловч ихэнх хорт бодисууд нь нүдэнд харагддаггүй байна.

Машины утаанд хэдэн зуун төрлийн бодис байдаг бөгөөд хамгийн хортой нь:


Угаарын хий (CO-Carbon Monoxide): Өнгөгүй, үнэргүй, маш хортой хий. Энэ нь цусан дахь хүчилтөрөгчийг зөөвөрлөх чадварыг бууруулдаг.

Азотын ислүүд (NOx): Уушгийг цочроож, амьсгалын замын өвчин (астма, бронхит) үүсгэдэг гол буруутан. Мөн “хүчлийн бороо” орох шалтгаан болдог.

Нарийн тоосонцор (PM2.5 ба PM10): Энэ бол хамгийн аюултай нь. Дизель хөдөлгүүртэй машинаас их гардаг хар утаа юм.

Эдгээр тоосонцор нь хүний үснээс 30 дахин жижиг тул амьсгалахад уушгины хамгийн гүн хэсэгт нэвтэрч, цаашлаад цусанд орж зүрх судасны өвчин, хорт хавдар үүсгэдэг болох нь нотлогдсон байдаг.

Тэгвэл машины утааг багасгахад хэрхэн хувь нэмрээ оруулах вэ?



Сурагч та автомашины хэрэглээгээ багасгаж, эрүүл амьдралын хэв маягийг сонгосноор байгальдаа болон гэр бүлдээ ашиг тустай төдийгүй машины утаанд өртөж буй дам нөлөөллийг ч бууруулах боломжтой. Та бүхэн ойролцоо амьдардаг найзтайгаа хамт сургууль руугаа алхаж хэвшээрэй. Алхахад хэт хол гэртэй бол нийтийн тээврээр зорчих болон дугуй унаж сургуульдаа явах боломжтой. Нэг хүн машинд сууж явснаас автобусаар 50 хүн хамт зорчих нь агаарын бохирдлыг бууруулах ач холбогдолтой.

ХООЛОНДОО АНХААРЬЯ!


Мах бол Монголчуудын уламжлалт хүнс юм. Нэг кг махыг бий болгохын тулд 100 кг өвс ургах хэмжээний газар нутаг шаардлагатай.

Яагаад мах идэх нь ургамал идэхээс илүү том мөр үлдээдэг вэ?

1-р түвшин (Ургамал): Нарны энергийг шингээж ургана. Энэ бол хамгийн хямд, хамгийн их энерги.

2-р түвшин (Мал): Хонь өвсийг иднэ. Гэхдээ идсэн өвснийхөө энергийн 90%-ийг зүгээр л амьдрахдаа (гүйх, амьсгалах, биеийн дулаанаа хадгалах, ялгадас гаргах) зарцуулж алддаг. Зөвхөн 10% нь л бие махбод (мах) болж үлддэг.

3-р түвшин (Хүн): Бид тэр хонийг идэх үед анхны ургамалд байсан энергийн маш бага хэсгийг л авч байна гэсэн үг.



Бидний хаясан хоолны үлдэгдэл гялгар уутанд боогдож, хогийн цэг дээр очоод, дээрээсээ олон тонн шороо, хогоор дарагддаг. Ингэснээр тэнд агаар (хүчилтөрөгч) байхгүй болно. Хүчилтөрөгчгүй орчинд хоол хүнс ялзрахад Метан (CH₄) гэдэг хий ялгардаг. Метан хий нь дэлхийг дулаацуулах чадвараараа нүүрстөрөгчийн давхар ислээс (CO₂) 25-80 дахин илүү хүчтэй.

Тиймээс та бүхэн экологийн үл мөрөө багасгаж, байгальд ээлтэй иргэд болоорой.

Гараг	Даалгавар	Биелүүлсэн бол + Биелүүлээгүй бол -
Даваа	Шүдээ угаахдаа усаа хаасан.	<input type="checkbox"/>
Мягмар	Дэлгүүрээс гялгар уут аваагүй (Даавуун тор ашигласан).	<input type="checkbox"/>
Лхагва	Өрөөнөөс гарахдаа гэрлээ унтраасан.	<input type="checkbox"/>
Пүрэв	Сургууль руугаа алхаж очсон, дугуй унасан эсвэл автобусаар явсан.	<input type="checkbox"/>
Баасан	Хуванцар сав худалдаж аваагүй (Усны саваа авч явсан).	<input type="checkbox"/>
Бямба	Хоолоо үлдээлгүй идсэн.	<input type="checkbox"/>
Ням	Гэрийнхэндээ энэ гарын авлагаас сурсан зүйлээ ярьж өгсөн.	<input type="checkbox"/>

Санамж: Нэг хүний үйлдэл бага мэт санагдавч бид бүгд хичээвэл асар том өөрчлөлт гарна. Чиний эхлүүлсэн өөрчлөлт гэр бүл, найз нөхдөд чинь үлгэр дуурайлал болно шүү! Үл мөрөө багасгах аяллаа хэнтэй үргэлжлүүлмээр байна вэ? Тэр хүнтэйгээ хамт номоо судлаарай.

**Бид юу хийж
чадах вэ?**



4.1.1 УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЭСРЭГ ХИЙСЭН БОДИТ АЛХМУУД

Нидерландын Боян Слат гэдэг хүү 16 настайдаа Грект амарч байхдаа далайд маш их хуванцар хог байгааг хараад, сургуулийнхаа төсөлд зориулж далай цэвэрлэх машин зохион бүтээсэн. Одоо түүний “The Ocean Cleanup” төсөл дэлхийн хамгийн том далай цэвэрлэх систем болсон.

Б. Феликс Финкбейнер гэдэг Герман охин 9 настайдаа ангийнхандаа “Дэлхийн улс бүрд сая мод тарья” гэж уриалж, “Plant-for-the-Planet” хөдөлгөөнийг эхлүүлсэн. Одоо тус байгууллага тэрбум тэрбум мод тариад байна.

Монгол сурагчид НҮБ-ын Хүүхдийн Сан, “Өсвөрийн Парламент” хөтөлбөр болон Скаутын холбооны дэмжлэгтэйгээр тусгай төхөөрөмж ашиглан “Агаарын чанарын мониторинг” хийж, Улаанбаатар хот, Баянхонгор, Говь-Алтай зэрэг аймгуудын сургууль, цэцэрлэг, гэрийнхээ дотоод агаарын чанарыг хэмжсэн. Улмаар гадаа утаатай байхад цонхоо онгойлгох, эсвэл агааржуулалт муутай байх үед анги доторх агаар гадаахтай ижил, заримдаа бүр илүү бохир байсныг тогтоожээ. Мөн ангид чийгтэй цэвэрлэгээ хийхдээ химийн бодис хэт их ашиглах нь агаарын чанарыг түр зуур муутгаж байгааг ч тогтоосон. Тэд үр дүнгээ нэгтгэж, Улсын Их Хурлын гишүүд болон Байгаль орчны сайдад танилцуулж, “Бидний ирээдүйг шийдэхдээ бидний оролцоог хангаач!” гэж уриалсан.

- Энэхүү санаачилгын үр дүнд (CHIP төслийн хүрээнд) олон цэцэрлэг, сургуулиудад агаар цэвэршүүлэгч, HEPA шүүлтүүртэй агаар сэлгэлтийн системүүдийг суурилуулж эхэлсэн.
- Эцэг эхчүүд гэрийн доторх агаараа хянаж сурсан.
- Хүүхдийн эрүүл мэнд, агаарын бохирдлын асуудал төрийн бодлогын төвд ороход хүүхдүүд өөрсдөө түлхэц болсон.



Налайх дүүрэгт:

Налайх дүүрэг нь өвлийн улиралд агаарын чанар хамгийн мууд тооцогдох бүсүүдийн нэг бөгөөд хөрсний элэгдэл нэмэгдэж, цөлжилт эрчимжиж байгаа нь байгаль орчин, иргэдийн эрүүл мэндэд бодит эрсдэл учруулж байна.

Хүүхдийг Ивээх Сан нийслэлийн Налайх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийг 2024-2027 онд хэрэгжүүлж байна. Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн хүрээнд нийслэлийн Налайх дүүргийн хүүхэд залуус, иргэдийн оролцоотойгоор мод тарьж, ургуулан уур амьсгалын өөрчлөлтөд эерэгээр нөлөөлөх, мөн тэдний уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх замаар уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх зорилготой. Энэхүү төслийн хүрээнд Налайх дүүргийн 5 га талбайд 5,000 гаруй мод тарих юм. Өнөөдрийн байдлаар, дүүргийн 1,000 гаруй иргэний (82% нь хүүхэд) оролцоотойгоор 24 төрлийн 4,000 гаруй мод тариад байна.



© Хүүхдийг Ивээх Сан

Мод яагаад чухал вэ?



5.1 МОД БА ОЙН АЧ ХОЛБОГДОЛ:

Мод тарих нь байгалиа хамгаалахаас гадна ирээдүйнхээ төлөө хийж чадах хамгийн энгийн алхам юм.

Агаарыг цэвэрлэнэ.

Нас бие гүйцсэн нэг мод жилд 20-25 кг нүүрстөрөгчийн давхар ислийг шингээж, гурван хүний амьсгалах хүчилтөрөгчийг үйлдвэрлэдэг. Тиймээс мод бол ойн зүрх юм.

Халуун агаарыг сэрүүцүүлнэ.

Модтой газар зуны халуунд 2-4°C-аар сэрүүн байдаг.

Амьтдын орон гэр болдог.

Нэг мод олон шувуу, шавж, амьтдын амьдрах орчин болдог.

Хүний сэтгэл санааг тайван байлгадаг

Модтой орчинд тоглодог хүүхдүүд илүү тайван, анхаарал төвлөрөх чадвар сайтай байдаг.



Ус, хөрсийг хамгаална.

Модны үндэс нь хөрсөнд усыг барьж шүүн, гол горхи тасралтгүй урсах нөхцөлийг бүрдүүлдэг. Ой устгахад ус хурдан ширгэж, ган гачиг нэмэгддэг. 2022 оны байдлаар, манай орны нийт нутаг дэвсгэрийн 77 орчим хувь нь цөлжиж, доройтсон бөгөөд 362 гол горхи, нуур тойром, булаг, шанд ширгэсэн байна.

5.2 ХАМТДАА МОД ТАРЬЦГААЯ!

Манай орны газар нутгийн 92% нь модгүй. Ердөө 8% орчим нь ойтой. Тиймээс Монголд тарьсан нэг мод ч асар их үнэ цэнтэй.



© themapcreators - БОАЖЯ

Модыг зөвхөн суулгаад орхих бус арчилж ургуулах нь хамгийн чухал юм шүү. Ялангуяа эхний 2-3 жилд тогтмол усалж, үндсийг нь бэхжүүлэх шаардлагатай.

Мод тарих хугацаа:

Хавар- 4 дүгээр сарын сүүлээс 5 дугаар сар

Намар- 9 дүгээр сарын сүүлээс 10 дугаар сар.

Ямар мод сонгох вэ?

- Өөрийн нутагт ургадаг
- Эрүүл, хугараагүй
- 30 см-ээс дээш өндөртэй суулгац (Нарс, хус, улиас, чацаргана г.м)

Мод тарих алхмууд

1. Нүх ухах- Суулгацын үндсээс 2 дахин том нүх ухна.
2. Модоо байрлуулах
3. Шороогоор булж нягтруулах
4. Сайтар услах-Суулгасны дараа шууд усална.
5. Хамгаалах-хаших
6. Арчлах-Тогтмол усалж, зэрлэгийг түүнэ.

Хүүхдүүд та бүхэн дараах алхмуудыг хэрэгжүүлж, байгаль дэлхийгээ хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулаарай.

1. Хүүхэд бүр нэг мод тарь.
2. Модондоо нэр өг.
3. Усалж, ажиглаж, тэмдэглэл хөтөл.

ХАВСРАЛТ-1

4. МИНИЙ МОДНЫ ӨДРИЙН ТЭМДЭГЛЭЛ

Анх тарьсан огноо, байршил, тоо ширхэг	Модны нэр	Мод тарихад тулгарсан бэрхшээл	Хэрхэн шийдвэрлэсэн талаарх тэмдэглэл
2025.09.12 “Ойн төгөл бүтээгч хүүхдүүд” төслийн талбайд, 5 мод	Голт бор	Яаж суулгахаа мэдэхгүй байсан. Мөчир нь хэт нарийн, хэврэг санагдаж яаж ургуулна даа гэсэн айдас байсан. Модны усалгааг хийхдээ усыг нь ихдүүлчих вий гэсэн болгоомж байсан.	Төслийн сургагч багш Д.Доржханд маш сайн зааж өгсөн. Мод бол нярай хүүхэдтэй ялгаагүй асаргаа шаарддаг хэдий ч 3 жилийн дараа бидэнд маш их үр шим өгдөг. Би суулгах аргачлалыг анхааралтай сонсож, багшийн заавраар дарааллын дагуу суулгасан. Зааврын дагуу суулгацанд 10-20 литр ус хийж, маналт хийсэн.

5.3 НОГООН САЙН ДУРЫН АЖИЛ

Ногоон сайн дурын ажилд оролцох нь өөртөө болон ирээдүйдээ оруулж буй хөрөнгө оруулалт юм. Түүнчлэн сайн дурын ажилд оролцож, мод тарьснаар:

- Олон улсын тэтгэлэг, их сургуульд ороход сайн дурын ажлын туршлага нь давуу тал болно.
- Байгальд хайртай, зөв үзэл бодолтой шинэ найз нөхөдтэй болно. Багийн ажил нь харилцаа, хамтран сурах чадварыг хөгжүүлдэг.
- Цэвэр агаарт хөдөлгөөнтэй байх нь бие бялдрыг чийрэгжүүлж, стрессийг бууруулдаг.

Ногоон сайн дурын ажлын төрлүүд

Хийх ажил	Үр дүн
Тарьсан модоо тогтмол услах, тойрсон хогийг цэвэрлэх, хөрсийг нь сийрэгжүүлэх.	Мод бүр амьд үлдэж, дүүрэгт оруулах эдийн засгийн өгөөж нь баталгаажна.
Бусад хүүхдүүдэд модны ач холбогдлыг таниулах. Мод тарихын ашиг тусыг тайлбарласан постер, видео хийж сошиал орчинд эсвэл сургууль дээрээ түгээх.	Илүү олон хүн модонд хайртай болж, байгаль хамгаалагчдын тоо нэмэгдэнэ.
Модны эргэн тойрон дахь гялгар уут, хуванцар савыг түүж ангилах.	Модны үндэс амьсгалж, хөрсний бохирдол багасна.

Ногоон сайн дурын ажилд хэрхэн оролцох вэ?

- Бүлэг үүсгэх: Найзуудтайгаа нийлээд баг болж, дүүргийнхээ тодорхой газрын модыг хариуцаж авах.
- Тэмдэглэл хөтлөх: Өөрийн арчилж буй модныхоо ургалтыг зургаар баримтжуулж, “Миний модны түүх” цомог үүсгэх.
- Дүүргийн захиргаанд хандах: “Бид эдгээр модноос 10-ыг нь хариуцаж арчилмаар байна” гэсэн хүсэлт гаргах (Энэ нь маш хариуцлагатай, үлгэр жишээ болох алхам болно).



(Green volunteer болох амархан).

5.4 НАЛАЙХ ДҮҮРГИЙН ОЙ БОЛОН ГАЗАР ЗҮЙН БҮТЭЦ

Бидний амьдарч буй Налайх дүүрэг нь цаг уурын эрс тэс, хуурай эх газрын уур амьсгалтай. Жилийн турш агаарын температур, цаг агаарын нөхцөл байнга өөрчлөгдөж, улирлын болон хоногийн хэлбэлзэл ихтэй байдаг. Улаанбаатар хотын төв хэсгийг бодвол агаарын температур харьцангуй сэрүүн, салхины урсгал сайтай байдаг нь агаарын бохирдол сарних нөхцөлийг бүрдүүлдэг.

Хэнтийн нурууны баруун өмнөд төгсгөл, Туул голын хөндийд байрладаг. Налайх дүүргийн байгалийн бүтцийн хамгийн чухал хэсэг нь Туул гол юм. Туул гол дүүргийн нутаг дэвсгэрээр дайран өнгөрөхдөө гүний усны томоохон нөөцийг бүрдүүлдэг.

Голын дагуух бургасан ой, нуга нь нүүдлийн шувууд болон зэрлэг амьтдын амьдрах таатай орчин болдог. Уулын хээрийн бүс учраас бэлчээрийн шимт ургамал, эмийн ургамлууд (алтан хундага, согоон чих г.м) элбэг.

Налайх нь уулын ойн хээрийн бүсэд хамаардаг тул байгалийн бүс бүслүүрийн шилжилтийн шинж чанарыг агуулдаг. Хойд хэсгийн уулсаар шинэс, нарс, хус мод бүхий ойтой. Энэхүү ой нь нийслэлийн агаарыг цэвэршүүлэх, усны нөөцийг барих өндөр ач холбогдолтой.

Байгалийн бүтцийн хувьд “Хан Хэнтийн дархан цаазат газар” болон “Туул голын сав газар”-ыг холбосон экологийн коридор юм. Тиймээс энд мод тарих, ойн зурвас байгуулах нь бичил уур амьсгалд чухал нөлөөтэй төдийгүй нийслэлийн тоосжилтыг бууруулах, усны нөөцийг хамгаалахад шийдвэрлэх үүрэгтэй.



© <https://www.nad.ub.gov.mn>

ХАВСРАЛТ-2

МИНИЙ ЭХ ДЭЛХИЙДЭЭ ӨГӨХ АМЛАЛТ

Налайх дүүргийнсургуулийн ... ангийн сурагч би “Эх дэлхийдээ өгөх 5 амлалт”-ыг өөрийн өдөр тутмын амьдралын хэв маяг, хариуцлагатай алхмуудаараа баталгаажуулахаа амлаж байна. Бид байгальд ээлтэй “Ногоон соёл”-ыг анги хамт олноороо түүчээлэн бусдыг уриалан дагуулах болно. Миний оролцоо – Бидний ирээдүй!

1. “Би экологийн ул мөр, уур амьсгалын өөрчлөлтийн талаарх мэдлэгээ байнга гүнзгийрүүлж, зөвхөн сэтгэл хөдлөлөөр бус, шинжлэх ухаанч тооцоололтойгоор байгаль орчиндоо хандах болно.”
2. Би зайлшгүй хэрэгтэй зүйлсээ л худалдан авч, нэг удаагийн хэрэглээнээс татгалзан, хог хаягдлаа ангилах замаар өөрийн үлдээх экологийн ул мөрийг хамгийн бага түвшинд барина.”
3. “Би зөвхөн мод тариад орхих бус түүнийг эрүүл, бат бөх мод болж ургах хүртэл нь арчлан хамгаална.
4. “Би байгальд ээлтэй амьдралын хэв маягийг хэвшүүлж, цахим орчинд эерэг мэдээлэл түгээх, хог хаяхгүй байхыг сануулах зэргээр гэр бүл, найз нөхөд, дүү нартаа зөв үлгэр дуурайл үзүүлэх болно.
5. “Би Налайх дүүргийнхээ хөрс, ус, агаарыг хамгаалахад идэвхтэй оролцож, төрөлх нутгаа илүү ногоон, эрүүл орчинтой болгож ирээдүй хойчдоо өвлүүлэн өгнө.”

Амлалт өгсөн огноо

.....

Гарын үсэг

.....

АШИГЛАСАН НОМ ЗҮЙ

1. С.Эрдэнэсүх, (2022). Уур амьсгалын өөрчлөлт түүнд дасан зохицох нь сургалтын гарын авлага, Улаанбаатар.
2. Хүүхдийг Ивээх Сан. (2025). Уур амьсгалын өөрчлөлт ба байгаль орчны боловсрол. Улаанбаатар.
3. Нэгдсэн Үндэсний Байгууллага, Эмнести Интернэшнл (2020). Хүний эрхийг хангах амлалтаа биелүүлэх нь сургалтын гарын авлага. Улаанбаатар.
4. Г. Даваадорж, Монгол ногоо төсөл (2016). Гэр бүлээрээ хамтран ажиллацгаая гарын авлага. Улаанбаатар.
5. Д. Энэбиш. (2007) Амьдрах ухаанд суралцах бичиг. Улаанбаатар.
6. Д. Даваадорж. (2019). Хөрс судлал. Улаанбаатар.
7. Д. Дагвадорж. (2019). Уур амьсгалын өөрчлөлт ба Монгол орон: Сорилт, боломж. Улаанбаатар.
8. Б. Жамбажамц. (2021). Цөлжилт ба газрын доройтлыг бууруулах арга технологиуд. Шинжлэх ухааны академи, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн.
9. Ж. Чогдон. (2022) Монгол орны ойжуулалт, ойг нөхөн сэргээх технологийн зааварчилгаа. Улаанбаатар: ШУА-ийн хэвлэл.
10. НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP). (2022). Уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй орон нутгийн хөгжил: Сургагч багшийн гарын авлага.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУАНЛИ

<p>Гуравдугаар сарын 21</p> <p>Дэлхийн ойн өдөр</p> <p>Энэ өдөр ойн санг хамгаалах, мод тарихыг уриалах зорилготой.</p>	<p>Гуравдугаар сарын 22</p> <p>Дэлхийн усны өдөр</p> <p>Ус, түүний ач холбогдол, хүн төрөлхтөнд тулгарч буй хамгийн том асуудал буюу цэвэр усны хомсдолын талаар олон нийтэд ойлгуулах өдөр.</p>	<p>Гуравдугаар сарын сүүлчийн 7 хоногийн бямба гараг</p> <p>Эх дэлхийн цаг</p> <p>Дэлхийн дулаарлын гол шалтгаануудын нэг болсон хүлэмжийн хийг бууруулахад хувь хүний оролцоо чухал гэдгийг сануулах зорилготой. Энэ өдөр 60 минут бүх гэрэлтүүлгээ унтрааж, эх дэлхийдээ амсхийх чөлөө өгөхийг сануулахаас гадна байгаль дэлхийгээ бүхэлд нь хамгаалахад уриалах зорилготой.</p>
<p>Дөрөвдүгээр сарын 22</p> <p>Эх дэлхийн өдөр</p> <p>Хүн төрөлхтний зүгээс эх дэлхийд учруулж байгаа байгаль орчны хор хохирлыг анхаарлын төвд оруулах зорилготой.</p>	<p>Тавдугаар сарын 3</p> <p>Нарны өдөр</p> <p>Энэ өдөр сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг ашиглах боломжийг сурталчлах, үүнд олон нийтийн анхаарлыг хандуулах зорилготой.</p>	<p>V, X дугаар сар 2 дахь долоо хоногийн бямба гараг</p> <p>Мод тарих үндэсний өдөр</p> <p>Цөлжилт, ган, зуд зэрэг байгалийн гамшигт үзэгдлийн давтамжийг бага ч гэсэн бууруулж, эх дэлхийгээ хэвээр нь авч үлдэхэд мод тарих нь чухал болохыг сурталчилж, бүх нийтээр мод тарих зорилготой.</p>
<p>Зургаадугаар сарын 17</p> <p>Дэлхийн цөлжилттэй тэмцэх өдөр</p> <p>Энэ өдөр цөлжилт, ган гачиг, газрын доройтлын хор уршгийг таниулах, тэмцэх, нөхөн сэргээхэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэдэг. Монгол улс 1996 онд уг конвенцид нэгдсэн бөгөөд нийт нутаг дэвсгэрийн 77 орчим хувь нь цөлжилтөд нэрвэгдээд байгаа юм.</p>	<p>10 дугаар сарын 6</p> <p>Дэлхийн амьдрах орчны өдөр</p> <p>Энэ өдрийг ДЭЛХИЙ дан ганц хүний амьдрах орчин биш, бусад амьд байгаль, ан амьтны өлгий мөн тул хүний үйл ажиллагаанаас үүдэлтэй ямар их аюул учирдаг болохыг тэдэнд ухааруулах зорилгоор тэмдэглэдэг.</p>	<p>10 дугаар сарын 13</p> <p>Байгалийн гамшгийг бууруулах олон улсын өдөр</p> <p>Энэ өдөр байгалийн гамшиг болох үер, хар салхи, ган, зуд зэргийн гамшиг тохиолдож буй шалтгаан, хүний буруутай үйл ажиллагаа, гамшгийн үр дагаврыг таниулж, шийдвэрлэх арга замыг хэлэлцэх, олон нийтэд ойлгуулах зорилготой.</p>



© Хүүхдийг Ивээх Сан



Монгол дахь Хүүхдийг Ивээх Сан

📍 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎️ +976-11-329365, +976-11-329371
📞 +976-11-329361

✉️ mongolia.secretary@savethechildren.org
🌐 www.savethechildren.mn
🇮🇸 Save the Children in Mongolia
🇺🇸 Save the Children MN
🇮🇸 Savethechildren.mongolia

